

Сайн Хоньчин

Эрин Сандэрсон

Хоньдоо маш их хайрладаг бөгөөд тэдний төлөө амиа өгөхөд ч бэлэн нэг хоньчны тухай түүхийг (сургаалт зүйрлэлийг) Есүс нэгэн өдөр ярьсан юм. Бид энэ түүхэнд гардаг хоньдтой адил юм. Хоньчин нь бидний Аврагч Есүс Христтэй адил юм. Есүсийг заримдаа Сайн Хоньчин гэдэг.

Зарим эцэг эх хүүхдүүдээ Аврагч дээр авчрахад Тэр хайраа харуулсан. Тэр “Хүүхдүүдийг над руу ирэхийг зөвшөөр, Тэднийг бүү хорь: Учир нь Бурханы хаанчлал бол тэдэн шиг хүмүүсийнх юм” (Лук 18:16) хэмээн хэлжээ. Тэрээр тэднийг гартаа тэврэн, адислав.

Нүдээ аниад, Есүс гараас тань барьж, адислал өгч байна хэмээн төсөөлөн бод. Та нар Есүсийн талаар сурч мэдэх юм уу, бодох үед Түүний хайрыг мэдэрч чадна. Ариун Сүнс та нарт Сайн Хоньчин—Есүс Христийн хайрыг мэдрэхэд тусалдаг. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.



ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭХ

зөвшөөр—боломж олго

тэднийг бүү хорь—тэднийг
бүү зогсоо

ГЭР БҮЛИЙН ЯРИЛЦЛАГА

Иохан 10:1-5, 11-16-г унш. Есүс ямар байдлаараа хоньчинтой адил болох талаар жагсаалт гаргаж, Аврагчийн хайрыг мэдэрсэн үеийнхээ тухай ярилц.

Дуу: “Тэр сайхан түүхийг уншихаараа би” (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, 60)

Судрууд: Лук 18:15–17; Иохан 10:1–5, 11–16

Видео бичлэгүүд: “Бяцхан хүүхдүүдийг над руу ирэхийг зөвшөөр”, “Бид бяцхан хүүхэд адил болох ёстой гэж Есүс заав” (Biblevideos.org)

БИДНИЙ САЙН ХОНЬЧИН

Энэ зургийг холдуул. Цагаан шугамнуудын дагуу үүнийг сэнс шиг нугал. Дараа нь үүнийг дэлгээд; баруун, зүүн талаас нь хар. Та нар Сайн Хоньчны хайрыг хэрхэн мэдэрдэг вэ?

СУДРЫН ЗӨВЛӨГӨӨ

Үйл явдал юм уу сургаал бүрийг аль номонд байдгийг харуулдаг "Сайн мэ-дээнүүд" гэсэн хүснэгтийг судруудын удирдамжаас олоорой. Зөвхөн Иоханы ном л Сайн Хоньчны тухай заадаг. Матай, Марк, Лук гэсэн гурван ном Есүс хүүхдүүдийг адисалж байгааг өгүүлдэг.

